

# 1

## НОГООН ЭДИЙН ЗАСАГ (НЭЗ) БА АЛБАН ЁСНЫ СТАТИСТИК

Б.Бадамцэцэг

### НЭЗ-ийн ерөнхий ойлголт, түүний ач тус

Дэлхийн улс орнууд урьд өмнө нь зөвхөн эдийн засгийн өсөлт буюу “economic growth” гэдэг ойлголтоор аливаа хөгжлийг төсөөлж, түүнд хүрэхийг эрмэлзэж байсан бол одоо ногоон өсөлт буюу “green growth” гэсэн ойлголтыг бий болгох, түүнийг хөгжлийн гол чиг баримжаагаа болгох зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Учир нь дэлхийн хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн үйл явцтай холбоотой байгалийн нөөцийн хэрэглээ эрс нэмэгдсэнээс шалтгаалж, хаягдал, бохирдлын хэмжээ экологийн даац, чадавхиас давж, үүнээс улбаалан байгаль, экологийн тэнцвэртэй байдал алдагдаж, түүнээс мөн улбаатай ихээхэн гарз хохирол хүний нийгэмд учирч байна. Иймд байгаль орчинтойгоо зохицсон эдийн засгийг хөгжүүлэх нь улс орны тогтвортой хөгжлийг хангах, тэр дундаа тогтвортой хөгжих хөгжлийн хамгийн зөв арга хэлбэр болж байна. Энэ асуудлын талаар дараах агуулгын хүрээнд дэлгэрүүлж авч үзье. Үүнд:

1. НЭЗ гэж юу вэ?
2. НЭЗ тогтвортой хөгжилд хүрэх шинэ зам мөн үү?
3. НЭЗ-т хэрхэн шилжих бэ?
4. НЭЗ-ийг авч хэрэгжүүлснээр гарах үр дагавар

**НЭЗ** гэж байгаль, хүрээлэн буй орчинд учирч буй эрсдэл, экологийн тэнцвэргүй байдлыг үр дүнтэйгээр бууруулах замаар нийгмийн сайн сайхан байдал, баялгийг бүтээх цогц ойлголт юм. Өөрөөр хэлбэл, хүний буруутай үйл ажиллагааны улмаас сүйдсэн байгаль, хүрээлэн буй орчинг хамгаалж, түүнийг хамгийн үр дүнтэй байдлаар ашигласнаар ядуурал, ажилгүйдлээс ангижирч тогтвортой хөгжилд хүрэх цорын ганц арга хэлбэр гэж эрдэмтэд томъёолж байна.

НЭЗ-ийн гол зорилго нь тухайн орны байгалийн нөөцийг ашиглаж, эдийн засгийг хөгжүүлэн, ногоон ажлын байрыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахын зэрэгцээ байгаль орчны сөрөг нөлөөг багасгахад оршино. Энд дурдагдаж буй тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхний өөрсдийн хэрэгцээгээ хангахуйц чадварыг алдагдуулахгүйгээр өнөө үеийнхний шаардлагад нийцсэн хөгжлийг хангах явдал юм. Тогтвортой хөгжилрүү чиглүүлэх НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО нь байгаль орчинд ээлтэй байдлаар эдийн засгийг өөрчлөх, үүнд, нийгмийн хөгжил, хүрээлэн буй орчны тогтвортой байдал, эрчим хүч, мэдээллийн технологи, ажлын байр, ядуурал гээд нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд хүрч хэрэгжих өргөн хүрээтэй асуудал юм.

Энэ бүхнээс үзвэл, НЭЗ нь экосистемийн үйлчилгээ болон амьтан, ургамлын тогтвортой амьдрах орчинг хангаж, хүлэмжийн хийн ялгарал, бохирдлыг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтаар дамжуулан орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхийг хэлнэ гэж тодорхойлж болох юм.

НЭЗ нь тогтвортой хөгжилд хүрэх шинэ зам төдийгүй, эдийн засгийн шинэ загвар юм. *Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн байдал* бол тогтвортой хөгжлийн тулгын гурван чулуу бөгөөд эдгээр асуудлуудын аль алинд нь түлхүү анхаарлаа хандуулсан тэр үед л эдийн засгийн шинэ гарц нээгдэх болно. Байгаль, хүрээлэн буй орчин байхгүй бол бид ажиллаж хөдөлмөрлөх, амьдрах тэр бүү хэл оршин тогтнох боломжгүй учир ногоон эдийн засгийг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага нь үүнээс үүдэн гарч ирж байна. Хойч үеийнхээ хэрэгцээнд зориулан байгалийн нөөц баялаг, байгаль орчноо хамгаалж, өвлүүлэх нэн чухал үүрэг өнөө үеийнхэнд бий. Тиймээс ч дэлхийн улс орнуудын ирээдүйн хөгжил нь байгалийн нөөцийн үр ашигтай зарцуулалт, байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн тогтолцоог бий болгоход чиглэгдэж байна.

НЭЗ-ийн элементүүдийг дараах байдлаар томъёолж болох юм. Үүнд:

1. Шинэ хөгжлийг хангаж чадах “ногоон” технологи
2. “Ногоон” эрчим – дэвшилтэт загвар
3. Амьдралын “ногоон” хэв маяг
4. Улс орнуудын дэлхий нийтийн зорилгод оруулах хувь нэмэр

Ногоон эдийн засагт шилжихэд нэг хүний хичээл зүтгэл бус нийт нийгмийн хичээл зүтгэл чухал юм. Энэхүү өөрчлөлтийг хийхийн тулд:

- “Ногоон” хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Инноваци буюу шинэ санаачлага нэвтрүүлэх
- Олон улсын харьцуулалт (глобал үнэлгээний систем) зэрэг асуудлууд тулгардаг байна.

Өөрчлөлт бүхэн нь бидний нүдэнд харагдаж, гарт баригдахгүй байж болох юм. Хот суурин, байшин барилга, тээвэр, ус эрчим хүч, бохирдолтой холбоотой хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь биет хэлбэрээр харагдаж байхад харин эдийн засгийн бодлого, тухайлбал, татварын систем, сангийн бодлого,

түүнчлэн хүмүүсийн аж амьдралын хэв маягийг өөрчлөх, шинээр техник технологи нэвтрүүлэх, шинэ санаачлага гаргах зэрэг нь өөрчлөлтийн бас нэг өөр хэлбэрээр илэрч болох юм.

Тогтвортой хөгжлийг ногоон эдийн засгийн бодлогоор дамжуулан хангахад тухайн улс орны зах зээл, макро эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин чухал нөлөөтэй. Үүнээс гадна олон улсын байгууллага, бусад хөгжингүй улс орны туршлага, дэмжлэг хэрэгтэй болох юм. Ногоон эдийн засгийг авч хэрэгжүүлэхэд хөгжиж буй улс орнуудад хэвшүүлэх нь хөгжингүй улс орнуудад хэрэгжүүлснээс илүү хялбар байдаг байна. Үүнтэй уялдуулан эдийн засгийн тогтвортой хөгжлийн тухай ойлголтыг доорх үндсэн зарчмуудад тулгуурлан авч үздэг болоод байна. Үүнд:

1. Хүлэмжийн хийн ялгарал багатай
2. Эрчмийн зарцуулалт багатай
3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон байх
4. Ногоон технологи ашигласан байх
5. Ногоон үйлдвэрлэл хөгжүүлэх, ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэх
6. Ногоон орчин, ногоон тээвэр ашиглах
7. Амьдралын “ногоон” хэрэглээг бий болгох, орчин бүрдүүлэх, хэвшүүлэх
8. Ногоон ажлын байр бий болгох зэрэг болно.

Тэдгээр өөрчлөлтийг аажим аажмаар хийснээр ногоон эдийн засгийг бүрэлдэн тогтох үндсийг тавьж, тогтвортой хөгжилд хүрэх боломжтой болох юм. Ногоон эдийн засагт шилжсэнээр нийгэмд иргэдийн оролцоо, чадавхийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, зах зээлийн шударга өрсөлдөөнийг бий болгох, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зэрэг олон боломж байгаагаас гадна хамгийн чухал нь цоо шинэ ЭРҮҮЛ НИЙГМИЙГ бий болгох боломж бидний өмнө байх болно.

### **НЭЗ-ийг хөгжүүлэх өнөөгийн бодит шаардлага, бусад улс орны туршлага**

Тогтвортой хөгжлийн түгээмэл үзэл баримтлал, хандлагад нийцүүлэн байгаль орчин, нийгмийн халамж тэнцвэрийг эрэмбэ дараатай хангах замаар эдийн засгаа экологийн баримжаатай хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын нийтлэг зорилт болж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг байгаль орчны даац, чадавхид нийцүүлэн тогтвортой хөгжүүлэх, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлэхэд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын үндэсний хөгжлийн хэтийн бодлого, стратегийн тухай улс төрийн намуудын үзэл баримтлал, байр суурийг нэгтгэн илэрхийлсэн, ард олныхоо санал бодлыг шингээн тусгасан, хүрэх үр дүн, хэрэгжих үе шатны зорилтуудыг тодорхой томъёолсон Үндэсний хөгжлийн цогц бодлого бүхий

хөтөлбөр боловсруулан баталж, түүнийгээ тууштай хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагыг иш үндэс болгож, “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичгийг УИХ 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор баталжээ.<sup>1</sup>

Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн дотор “стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглаж, хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй, өндөр өсөлтийг хангаж, орчин үеийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, “эко-системийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалан ашиглах замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгох” чиглэлийг тодорхойлсон юм.

Дэлхийн улс орнуудын хувьд тогтвортой хөгжил, түүний дотор НЭЗ-ийг хөгжүүлэх чиглэлээр олон чухал үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, санал, санаачилгын талаар зарим жишээг авч үзье.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг тооцоолох арга зүй нь байгалийн нөөцийн бууралт, байгаль орчны доройтлыг тусгадаггүй байдлыг харгалзан Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) байгаль орчны статистикийн аргазүйн чиглэлээр судалгаа хийж эхэлсэн. 1970-аад оноос эхлэн НҮБ болон Дэлхийн банк ногоон ДНБ-ий үзэл баримтлалыг хөгжүүлж эхэлсэн байна. Хорин жилийн дараа буюу 1993 онд дээрх хоёр байгууллага хамтран “Байгаль орчин эдийн засгийн нэгдсэн данс 1993 (БОЭЗНД-1993)” нэртэй гарын авлагыг хамтран боловсруулж, гаргасан. Түүнээс арван жилийн дараа байгаль орчны статистикийн суурь болох БОЭЗНД-2003-ийг шинэчлэн гаргасан байна. Цаашид энэхүү гарын авлага нь Ногоон ДНБ-ийг тооцох арга зүйн суурь материал болно гэж үзэж байна.

Түүнчлэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Дэлхийн банк, Олон улсын эрчим хүчний байгууллага зэрэг олон байгууллагуудаас НЭЗ-ийн үзүүлэлтийн системийг бүрдүүлэх, арга зүй, ойлголт, тодорхойлолт, ашиглах ангиллыг бий болгох чиглэлд багагүй зүйлийг хийж гүйцэтгээд байна.

#### Солонгос улс:

Солонгос улс хөгжлийн зорилгоо: “Хүлэмжийн хийг хамгийн бага түвшинд байлгаж, эдийн засгийн өсөлтийг хангах” гэж тодорхойлсон байна. НЭЗ-ийн асуудлыг хөндөж тавих дараах 3 элемент байна гэж үзэж байгаа бөгөөд тэдгээрээс улбаалан хөгжлийн шинэ арга зам хэрэгтэйг гэдгийг гаргаж тавьж байна. Үүнд:

<sup>1</sup> Төрийн мэдээлэл сэтгүүл, 2008 оны дугаар 7, 8



Тус улс нь эрчим хүчний хэрэглээгээрээ дэлхийд 10-т ордог, эрчим хүчний хэрэглээний дийлэнхийг импортоор хангадаг, эрчим хүчний үнэ өндөр, ихээхэн хэлбэлзэлтэй болж байна.

Цаг агаарын өөрчлөлтийн хувьд Солонгосын томоохон 6 хотын агаарын температур, хур тундас олон жилийн дунджаас нэмэгдэж, ой, ойт хээрийн бүсэд экосистем алдагдаж, үер ус, байгалийн гамшиг нь эдийн засаг, нийгмийн амьдралд муу нөлөө үзүүлж байна. Энэ бүгдээс эдийн засгийн өсөлтийн хурдац саарч байна гэж үзэж байна.

#### Хятад улс:

НЭЗ-ийг хөгжүүлэх чиглэлээр багагүй ажлуудыг эхлүүлсэн бөгөөд 2015 он гэхэд НЭЗ-ийн голлох салбаруудад 468 тэрбум \$-ийг оруулахаар төлөвлөж байна. Энэ нь өнгөрсөн 5 жилийн гүйцэтгэлээс даруй 2 дахин их хэмжээ юм.

Хятад улсын хувьд НЭЗ-ийг хэмжих үзүүлэлтийн системийг дараах байдлаар бүрдүүлж байна.

1. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)
2. Шинэ технологи нэвтрүүлсний үр дүнд бий болсон нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь
3. Нэгж ДНБ-д ногдох нөөцийн хэрэглээ
4. Нэгж ДНБ-д ногдох хүлэмжийн хийн ялгаралт
5. Төрийн үйлчилгээ
6. Судалгаа шинжилгээний зардлын ДНБ-д эзлэх хувь

#### Австрали:

Австралийн статистикийн байгууллагаас хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах чиглэлээр Австрали, Хятад, Герман, Энэтхэг, Япон, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос, Англи, Америк зэрэг орнуудын 1000 гаруй бодлогын шийдлийг судалсан байна.

Тэдгээр бодлогын шийдлүүд нь дараах чиглэлээр хийгдэж байна. Үүнд:

1. Нүүрстөрөгчийн үнэлгээг зөв зохистой тогтоох
2. Сэргээгдэх эрчим хүчний түвшинг тогтоох, технологийн стандарт болон эрчим хүчний үр ашгийг тодорхойлох, холбогдох хууль дүрмийг бий болгох зэргээр хяналтын механизмыг бүрдүүлэх
3. Судалгаа шинжилгээний ажлыг дэмжих, өргөжүүлэх
4. Татвар, татаасын хэмжээг оновчтой тогтоох
5. Тодорхой үйл ажиллагаанд зарцуулах шууд зардлуудыг авч үзэх зэрэг болно.

Австрали улсын Засгийн газраас 2020 онд гэхэд хүлэмжийн хийн ялгаралтын түвшинг 2000 оны түвшингээс 5% бууруулна гэж томъёолсон байна.

Энэтхэг улс:

Байгаль орчны статистикийг (БОС)-ийг хөгжүүлэх оүйл ажиллагааг тус улсад 1981 оноос статистикийн байгууллагын санаачилгаар эхэлсэн бөгөөд түүнээс хойшхи хугацаанд шат дараалсан олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 1985 онд улсын түвшний мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулж, 1990 онд байгаль орчин, ногоон эдийн засгийг тооцож, тодорхойлох үзүүлэлтийн хүрээг тодорхойлсон, 1996 онд БОС-ийн удирдах хороог улсын түвшинд байгуулсан.

Энэтхэг улс байгаль орчин, байгалийн нөөцийн данс байгуулах 3 шатны ажлыг одоо хийж гүйцэтгэж байна. Үүнд:

1. Биет хэмжээний данс байгуулах
2. Мөнгөн үнэлгээний данс байгуулах
3. Эдийн засгийн нэгдсэн данс байгуулах

Дээрх 3 үе шатны ажлын хүрээнд байгуулсан биет хэмжээний дансыг үнэлж, мөнгөн дүнгээрх данс байгуулаад, үр дүнд нь байгалийн нөөцийн цэвэр өөрчлөлтийг тооцож, улсын хэмжээний ногоон дотоодын нийт бүтээгдэхүүн (НДНБ)-ийг тооцох ажлыг одоо хийж байна. Энэтхэг улс өнгөрсөн хугацаанд судалгааны олон ажлуудыг хийж байгаа бөгөөд энэ ажилд эрдэм шинжилгээний институци, их дээд сургууль өргөнөөр татан оролцуулж байгаагаараа онцлог юм.

Мексик:

2003 оноос эхэлж НДНБ-ийн тооцооллыг хийж, эдийн засгийн өсөлт нь БО-ны нөлөөлөлтэй хэрхэн уялдаж байгааг тодорхойлж байна. 2009 оны байдлаар НДНБ, ДНБ-ий харьцаа 92.4 хувь байна гэж тооцоолжээ.

**НЭЗ-ийг хэмжихэд албан ёсны статистикийн үүрэг**

Тогтвортой хөгжлийн төлөв байдал, түүний дотор ногоон эдийн засгийн түвшинг илтгэн харуулах үзүүлэлтүүдийг тодорхойлох, цаашилбал, тооцох шаардлага улс орнуудын статистикийн байгууллагын өмнө тулгарч байгаа зорилтын нэг нь болж байна. Мэргэжлийн түвшинд боловсруулан гаргасан тоо мэдээлэлгүйгээр төр засгийн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх, нөөцийг үр ашигтай хуваарилах, ашиглах, цаашдын зорилго, зорилтуудыг тодорхойлох боломжгүй билээ.

Байгаль орчны үзүүлэлтээр улс орны эдийн засгийн агрегат үзүүлэлтүүдийг засварлан тооцож, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хянах асуудал манай улсын хувьд урьд өмнө хэрэгжиж байгаагүй харьцангуй үйл ажиллагаа юм.

Дээрх нөхцөл байдалтай уялдан статистикийн байгууллагын зүгээс юу хийх болон хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ гэсэн асуулт гарах бөгөөд юуны өмнө

НЭЗ-ийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнг хэмжих, хянах, шалгуур үзүүлэлтийн системийг бий болгох, үүний тулд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллагууд, институт, Засгийн газрын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага гарч байна.

НЭЗ-ийн түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох чиглэлд олон улсын мэргэшсэн байгууллагууд төдийгүй зарим улс орнуудын хувьд ч багагүй туршлага хуримтлуулж, үзүүлэлтийн нэгдсэн системийг бүрдүүлж чаджээ. Дараах хүснэгтээр Солонгос улсын гаргасан үзүүлэлтийн системийг харуулъя. Тус улсын хувьд НЭЗ-ийг хэмжих 3 дэд сэдвийн хүрээнд дараах 30-аад үзүүлэлтийг тодорхойлсон байна.

**1. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон эрчим хүчний бие даасан байдал**

Дэд сэдэв	Үзүүлэлт
1. Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах арга хэмжээ	Хүлэмжийн хийн нийт ялгаралт
	Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаралт
	ДНБ-ий нэг нэгжид ногдох хүлэмжийн хийн ялгаралт
2. Нөхөн сэргээхгүй түлшний хэрэглээг бууруулах, эрчим хүчний бие даасан байдлыг сайжруулах	ДНБ-ий нэг нэгжид ногдох эрчим хүчний хэрэглээ
	Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ
	Нөхөн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний эзлэх хувь
3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдлыг сайжруулах	Халдварт өвчлөлийн хамгаалалт
	Томоохон голын усны бохирдол
	Осол гамшгаас урьдчилан сэргийлэхээр зарцуулсан зардлын хувь

**2. Эдийн засгийн өсөлтийн шинэ механизмыг бий болгох**

Дэд сэдэв	Үзүүлэлт
4. Ногоон технологийг хөгжүүлэх	Судалгаа, хөгжлийн зардал дахь “ногоон” судалгаа, хөгжлийн зардлын эзлэх хувь
	ДНБ дэх “ногоон” судалгаа, хөгжлийн хөрөнгө оруулалт
	Ногоон пациент эзэмшигчийн тоо
5. Эдийн засгийн салбарыг ногооруулах, ногоон эдийн загсийг дэмжих	ДНБ-ий нэг нэгжид ногдох нэгж материалын хэрэглээ
	“Ногоон” бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	“Ногоон” хөдөлмөр эрхлэлт

6. Эдийн засгийн бүтцийг сайжруулах	Мэдлэгт суурилсан “бүтээгдэхүүн”
	Мэдээлэл, холбоо, технологийн салбарын бүтээгдэхүүн
7. Ногоон эдийн засгийн бүтцэд суурилсан инженерчлэл	Хүлэмжийн хийн ялгаралын худалдааны хэмжээ
	ISO14001 батламжтай менежменттэй байгууллага
	Ногоон эдийн засгийг хөгжүүлэх засгийн газрын сан

### 3. Амьдралын чанарыг сайжруулах, олон улсын оролцоог нэмэгдүүлэх

Дэд сэдэв	Үзүүлэлт
8. Газар, ус, байгууламж, тээврийн дэд бүтцийг ногооруулах	Нийт газарт ойн газрын эзлэх хувь
	Ногоон байгууламж
	Нийтийн тээврийн шинж чанар
	ДНБ дэх байгаль орчныг хамгаалах зардал
9. Өдөр тутмын амьдралд ногоон хувьслыг бий болгох	Байгаль орчны талаарх олон нийтийн үзэл бодол
	Нэг хүнд ногдох дотоодын эрчим хүчний хэрэглээ
	Нэг хүнд ногдох дотоодын усны хэрэглээ
10. Олон улсын түвшинд ногоон өсөлтийг тэргүүлэх загвар болгох	“Цэвэр” хөгжлийн механизм
	ҮНӨ-д дэх ногоон ОДА-ийн эзлэх хувь

### Дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэ зууны хөгжлийн гол хандлага болох тогтвортой хөгжлийн үндсэн зарчим нь Байгаль орчин-эдийн засгийн хөгжлийн оновчтой харьцааг бүрдүүлж, түүний үндсэн дээр хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, байгалийн баялгийг боломжит хэмжээгээр нь зохистойгоор ашиглах, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын үйлдвэрлэлээс голчлон хамаарах болж байгаа билээ. Цаашид хөгжлийн чиг хандлагаа томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулан, уул уурхайд суурилсан боловсруулах аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх явдал гэж тодорхойлсон.

Эдийн засгийн энэхүү өсөлт, үүний дотор уул уурхайн салбарын өсөлтийн зэрэгцээ байгалийн нөөцийн шавхагдалт, байгалийн доройтлын асуудал хурцаар тавигдах болж байна. Уул уурхайн салбарын өсөлтөөс үүдсэн эдийн засгийн өсөлт хүмүүсийн амьжиргаанд төдийлөн нөлөө үзүүлэхгүй, ухсан нүх,



овоолсон шороо, химийн бодисоор хордсон хөрс, ус үлдэж байгааг иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд хурцаар шүүмжлэх боллоо. Цаашид Тавантолгой, Оюутолгой зэрэг томоохон орд газруудыг ашиглаж эхлэхтэй холбоотойгоор асуудал улам бүр хүчтэйгээр тавигдана.

Энэ бүхнээс үүдэн сүүлийн жилүүдэд бидний бий болгосон баялаг буюу ДНБ-ий хичнээн хувь нь байгалийн баялгаа ашигласны, байгалиа бохирдуулсны үр дүнд бий болсон болохыг тодорхойлж, улмаар энэ хэмжээгээр бий болгосон баялгийн тооцооллыг бууруулан тэр хэмжээгээр тогтвортой хөгжлийг хангах, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах, байгалийн нөөцийн ашиглалт, байгалийн бохирдлын хэмжээнд хяналт тавих зайлшгүй шаардлага урган гарч байна.

Энэ бүгдтэй уялдан НЭЗ-ийн түвшин, хандлагыг тооцохын ач холбогдлыг таниулах, оролцогч талуудын хүсэл эрмэлзэлийг бий болгох, үзүүлэлтийг тооцох онол арга зүйг судлан үзэх, байгаль орчин, эдийн засгийн статистикийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай аргачлал, аргазүйг боловсруулах, холбогдох чиглэлээр судалгаа явуулж үр дүнг нэгтгэх зэрэг ажлуудыг эхлүүлэх ёстой болж байна.

Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд онол аргазүйн мэдлэг, боловсон хүчний чадавхи, шаардлагатай аргачлалыг боловсруулах, судалгаа явуулах санхүүжилтийг олох зэрэг эрслүүд тохиолдож болох хэдий ч холбогдох талуудыг оролцоог бий болгож, тэдний үйл ажиллагааг үр дүнтэй уялдуулснаар эдгээр бэрхшээлийг даван туулах боломжтой.

Асуудлыг шийдвэрлэх дараагийн үе шатанд асуудлыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох шаардлагатай. Ногоон ДНБ-ийг тооцох арга зүйн суурь нь БОЭЗДС бөгөөд манай улсын статистикийн практикт энэхүү системийг шат дараатайгаар, хэсэгчлэн өөрийн орны онцлог нийцүүлэн нэвтрүүлэх хэрэгтэй гэж үзэж байна. Асуудлыг шийдвэрлэхэд тал бүрийн оролцоо чухал. Тухайлбал, байгалийн бохирдлын үнэлгээний асуудал дан ганц статистикийн байгууллагын асуудал бус асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоо энд маш чухал юм.

Энэ хүрээнд тавигдах дараагийн асуудал бол манай орны нөхцөлд тохирсон үзүүлэлтийн системийг бүрдүүлэх асуудал юм.

НЭЗ-ийн түвшинг тооцож, тодорхойлох шалгуур үзүүлэлтийг бий болгохдоо юуны өмнө олон улсын байгууллагуудаас мөрдөхөөр зөвлөмж болгож байгаа болон эдийн засгийн бүтэц ижил төстэй улс орнуудын санал болгож байгаа үзүүлэлтүүдийг жишиг болгохын зэрэгцээ өөрийн орны онцлогийг тусгасан байх, түүнчлэн тухайн үзүүлэлтийн тогтвортой байдал, чухал, хэрэгцээтэй байдлыг харгалзан үзсэн байвал зохино. Мөн түүнчлэн статистикийн байгууллагаас одоогоор нэгтгэн гаргаж байгаа үзүүлэлтүүд, тухайлбал, 5 жил тутам байгуулдаг Нөөц, ашиглалтын хүснэгт, Салбар

хоорондын тэнцэл, аж үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг салбарын статистикийн үзүүлэлтийг илүү дэлгэрэнгүйгээр нэгтгэн гаргаж, давтамжийг нь цаашид нэмэгдүүлэх шаардлага тавигдах болно. Ингэснээр Ногоон өсөлтийн хандлагыг гаргах боломжтой болж, бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

**Ном зүй:**

**Монгол хэл дээр**

1. “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2008 оны 7,8 дугаар.
2. “Тогтвортой хөгжлийн үзүүлэлтийн систем”, Монгол улсын тогтвортой хөгжил төсөл хэрэгжүүлэх нэгж. Улаанбаатар хот. 1997 он.
3. “Байгаль орчин, эдийн засгийн нэгдсэн туслах данс”, Орч. Макро эдийн засаг бизнес статистикийн газар, Үндэсний статистикийн газар. Улаанбаатар хот. 2004 он.
4. “Байгаль орчны эдийн засаг ба байгалийн нөөцийн тогтвортой менежмент”, Х.Ыханбай, Улаанбаатар хот, 2005 он.

**Англи хэл дээр**

5. “Integrated Environmental and Economic Accounting 2003– Handbook of National Account”, United Nations, European Commission, International Monetary Fund, Organisation for Economic Co-operation and Development and World Bank, Studies in Methods, Handbook of National Accounting, 2003.
6. “System of Integrated Environmental and Economic Accounting (SEAA)” Lecture presentation, A.C.Kulshreshta. UN Statistical Institute for Asia and the Pacific. Tokyo, 2006.
7. International seminar on Green economy and Official Statistics, Seoul, Republic of Korea, 6-8 July 2011.
8. “Paper 9: Green GDP and Natural Resources Accounting Perspective for Malaysia”, Prof. Jamal b. Othman, Kuala Lumpur, 20<sup>th</sup> September, 2005.
9. “Integrated Environmental and Economic Accounting 2003 – Glossary (Draft for Comments)”, United Nations, 2004.
10. “Green GDP Accounting in China: Review and Outlook” Wang Jinnan, Jiang Hongqiang and Yu Fang, Beijing, 2007.
11. “Environmental Accounting – Concept Note” Dr S.Haripriya. Chennai, 2007.